



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 10 сарын 11 өдөр

Дугаар A/59

Даланзадгад

Г Дархлаажуулалтын 10 хоногийг зохион
байгуулах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.12.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2019 оны 10 дугаар сарын 04-17-ны өдрүүдэд “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулсугай.

2. “Дархлаажуулалтын 10 хоног”-оор эрүүл мэндийн байгууллагын ажилтан, жирэмсэн эмэгтэй болон архаг хууч өвчтэй, 65-с дээш насны зорилтолт бүлгийн хүн амыг улирлын томуугийн эсрэг вакцинаар тархвар судлалын заалтаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулж хамтран ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Улирлын томуугийн эсрэг вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг нэгдүгээр, вакцины зааврыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Томуу, томуу төст өвчинеөс сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлыг талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн /Г.Мөнхзул/-д даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга /М.Булганчимэг/-д даалгасугай.

ДАРГА Ц.ӨНӨРЖАРГАЛ

4619287282
ТУЗ1732 9047751

46190081

C:\ Desktop\2019 on TUSHAAL

Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн
А/59 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

4619287282
ТУ31732 9047751

ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМЫГ ДАРХЛААЖУУЛАХ БҮГД НАЙРАМДАХ
СОЛОНГОС УЛСЫН ГРИЙН КРОСС ҮЙЛДВЭРИЙН УЛИРЛЫН ТОМУУГИЙН
ЭСРЭГ ИДЭВХГҮЙЖҮҮЛСЭН “GC FLU” ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	ЭМБ-ын нэр	Эрүүл мэндийн байгууллагын ажилтан	Зорилтот бүлгийн хүн ам	Тариур (ширхэг)	Сайн дурын дархлаажуулалт
1	Баяндалай	20	20	40	10
2	Баян-Овоо	20	20	40	30
3	Булган	15	15	30	30
4	Гурвантэс	20	40	60	150
5	Мандал-Овоо	20	20	40	0
6	Манлай	20	30	50	50
7	Номгон	20	20	40	100
8	Ноён	30	20	50	0
9	Сэврэй	15	15	30	20
10	Ханбогд	31	49	80	100
11	Ханхонгор	18	12	30	10
12	Хүрмэн	18	22	40	30
13	Цогт-Овоо	21	19	40	20
14	Цогтцэций	65	35	100	450
15	Шимбилэг	15	55	70	120
16	Өнө-Орших	8	52	60	50
17	Энхийн хүслэн	14	56	70	70
18	Боэт	150		150	
19	Эмг	32		32	
20	Зөстөв	15		15	
21	Хувийн хэвшил	83		83	
Нийт дүн		650	500	1150	1240

Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн
A/59 тоот тушаалын хөёрдугаар хавсралт

4619287282
ТУ31732 8047751

ТОМУУГИЙН ЭСРЭГ ИДЭВХИГҮЙЖҮҮЛСЭН (GC FLU)
ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Томуугийн эсрэг идэвхигүйжүүлсэн (GC FLU) вакцин нь томуугийн вирусын антигенийг идэвхигүйжүүлж гарган авсан, ДЭМБ-ын гэрчилгээтэй вакцин юм.

Тун ба тарих арга:

Вакциныг гарын бугалганы булчинд тарина. Тарих тун:

- 6 сар-3 хүртэлх (35 сар буюу 2 нас 11 сар 29 хоног) насны хүүхдэд 0,25 мл-ээр 28 хоногийн зйтай 2 удаа тарина.
- 3-аас дээш настай хүүхэд болон насанд хүрэгчдэд 0.5 мл-ээр 1 удаа тарина.

Найрлага:

Уг вакцин нь ДЭМБ-аас зөвлөсөн томуугийн вирусийн 3 дэд хэвшинжийг агуулсан. 1мл вакцины агууламж:

Цэвэршүүлж идэвхигүйжүүлсэн томуугийн А хүрээ A/Brisbane/02/2018IVR-190 (H1N1).....30 μ g

Цэвэршүүлж идэвхигүйжүүлсэн томуугийн вирусийн антиген А хүрээ

A/Kansas/14/2017 NYMC X –327

(H3N2.....30 μ g

Цэвэршүүлж идэвхигүйжүүлсэн томуугийн вирусийн антиген В хүрээ

B/Maryland/15/2016 NYMC BX-69A.....30 μ g

Хэрэглэх арга, тун хэмжээ:

- Вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгт заавал хамруулна.
- Вакциныг хэрэглэхээс өмнө зөөлөн сэгсэрнэ.
- Уг вакциныг бусад вакцинтай нэг өдөр хийж болох бөгөөд тарих талбай өөр байна.
- Тарилгын стандартыг баримтлан ажиллана.
- Вакцин хийлгэж байгаа хүмүүст тарьсан хэсгийг цэвэр байлгах талаар ховор болон маш ховор тохиолдох урвал, хүндрэл илэрсэн тохиолдолд яаралтай эмчид хандах талаар зөвлөх хэрэгтэй.
- Вакциныг 6-9 хүртэлх сартай хүүхдэд гуяны булчингийн гадна талыг 3 хуваасны дээд, дунд хэсгийн заагт, 9 сар ба түүнээс дээш насны хүүхэд,



насанд хүрэгчдэд гарын бугалганы дельтойд (гурван толгойт) булчинд тарина.

Тарих тун:

- 6 сар ба-3 хүртэлх (35 сар буюу 2 нас 11 сар 29 хоног) насны хүүхдэд 0,25мл-ээр 28 хоногийн зйтай 2 удаа тарина.
- 3-аас дээш настай хүүхэд болон насанд хүрэгчдэд 0.5мл-ээр 1 удаа тарина.

Эсрэг заалт:

Дараах тохиолдолд вакциныг тарьж болохгүй. Үүнд:

1. Өмнө нь уг вакциныг хийлгэхэд анафилаксын шок илэрч байсан хүнд;
2. Тахианы мах, өндөг, вакцины найрлаганд орсон аль нэг бодист хэт мэдрэг хүнд;
3. Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт өгсөн хүнд;
4. Өмнө нь томуугийн эсрэг вакцин хийлгэсний дараа 6 долоо хоногийн дотор Гиллен-Баррын хам шинж илэрч байсан хүнд;
5. Дархлал дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа хүнд хийхийг хориглоно.

Дархлаажуулалтын дараах урвал

1. Хэсэг газар улайх, хавдах, өвдөх болон халуурах, чичруүдэс хүрэх, толгой өвдөх, ядарч сульдах, бөөлжих зэрэг хариу урвал илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа ихэвчлэн алга болдог.
2. Ховор тохиолдолд энцефаломиелит тохиолдож болно.
3. Маш ховор тохиолдолд харшлын урвал юм уу анафилактик шок илэрч болно. Шокийн үед хэрэглэх адреналин болон яаралтай тусламжийн эм тариаг бэлэн байлгана.
4. Маш ховор тохиолдолд системийн болон мэдрэлийн тогтолцооны эмгэгүүд болох саажилт, невралги, мэдрэлийн тогтолцооны үрэвсэл гэх мэт (Гиллен-Баррын хам шинж гэх мэт) шинж тэмдгүүд илэрч болно.

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд

Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйд вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсний аль ч хугацаанд болон хөхүүл үед томуугийн вакцин хийлгэж болно.

Хадгалалт, тээвэрлэлт, савлагаа

Вакцин чь 10 хүн тунгаар савлагдсан. Вакцин болон найруулсан вакциныг гэрлээс хамгаалж +2-+8 хэмд харанхуй газар хадгалж, тээвэрлэнэ, хөлдөөж болохгүй. Үйлдвэрлэснээс хойш 12 сар хүчинтэй.

Үйлдвэрлэгч: Green Cross Corporation, БНСУ